

Р.Ф.УНГЕРНИЙ МОНГОЛ ДАХЬ АЖИЛЛАГАА

(үргэлжлэл, түрүүч нь өмнөх дугаарт)

С.Дамдинсүрэн***III**

Унгерний умар зүгийн давшилт нь зөвхөн Хятадын цэргийн эсрэг тэмцлийн хүрээнээс хальж Зөвлөлт Оросын эсрэг, Монголын Ардын түр засгийн газрын эсрэг хандсанаар шинэ нөхцөл байдал үүссэн байна. Монголд Зөвлөлт Оросын цэргийг оруулах жинтэй шалтаг гарав. Энэ нь цэрэг дайны талаасаа Зөвлөлт Оросын аюултай бөгөөд хүчтэй дайсан Унгернийг бут цохиход зайлшгүй хэрэгтэй зүйл болжээ. Улс төрийн талаасаа энэ бол улс орныхоо нөхцөл байдлыг хяналтандаа авах гэсэн Монголын залуу хувьсгалт хүчинд туслах үүднээс ч бас зайлшгүй чухал байв. Монголд цэрэг оруулах тухай асуудал бүр 1920 оны намраас тавигдаж байжээ. Анх Унгерн Хүрээнд тулж ирсэн үед орон нутгийн Хятадын командлал ЗСБНХОУ ба Алс Дорнодын Бүгд Найрамдах улсын засаг захиргаадал хандаж тусламж хүсчээ. Унгерний цэрэг Монголд орж ирсэнтэй холбогдуулан ОК(Б) намын Төв хорооны Сибирийн товчооны Дорно дахины ард түмний секцийн Тэргүүлэгчид ба Монгол-Төвдийн хэлтсийн хамтарсан яаралтай хуралдаан 1920 оны 10 дугаар сарын 29-нд Эрхүү хотноо хуралджээ. Тус хуралд Монголын төлөөлөгчдийн үзэл бодлын талаар С.С. Борисов мэдэгдэл хийхдээ: Тэд “Унгерн бол нэг их айгаад байх хадны мангаа биш гэж бодож байгаа юм. Унгерн бол Семеновын цэргийн ялагдсаныхаа дараа тарж бутран орогнох орон хайж Хүрээнд ирсэн хэсэг учраас тайж ноёдын дотор ч амжилт олж чадахгүй гэж тэд үзэж байна. Тийм учраас тэр ямар ч оролдлого хийлээ гэсэн нэг их айж эмээх хэрэггүй гэж бодож байна”¹³ гэжээ. Гэвч уг хуралдаанаас Унгерн монголд орж ирснээр Монголын Хатгал, Вангийн хүрээ, Хиагт, Ерөө, Хараа, Шаамар болон Баруун Монгол, Урианхайн хязгаар зэрэг олон газар тархсан цагаантны хүчийг ашиглах, тэдгээрийг нэгтгэн Зөвлөлт Оросын эсрэг Монголын фронт бий болох, улмаар тэднээр дамжин Японы нөлөө ч өсөх аюул тулгарч

* С.Дамдинсүрэн - ОУСХ-ийн тэргүүлэх ажилтан, доктор, профессор

байна гэж үзжээ. Тус хурлаас тогтоохдоо: цагаантан Монголд бүгж Зөвлөлт Орос улсад шинэ аюул занал учруулах, монголчуудад нөлөөгөө дэлгэрүүлж, тэднээс шинэ цэргийн хүч бүрэлдэхэд саад учруулах, Японы үзүүлэх нөлөөг зайлуулах, хятадын эзэгнэлийг устгах зорилгоор Зөвлөлт Оросын цэргийг Монголын нутагт нэн даруй оруулах нь чухал гэж заажээ. Хуралдаан бас Монголын нэр нөлөө бүхий хүмүүсийг оролцуулан автономит түр засгийн газар байгуулах шаардлагатай бөгөөд энэ асуудлын талаарх санаачилгыг Монголын төлөөлөгчдөд олгохоор тогтжээ. Тэгээд тус засгийн газраас Зөвлөлт Оросын засгийн газарт хандаж цэргийн тусламж үзүүлэх асуудлыг тавибал зохино¹⁴ гэж үзсэн байна. Үүний дараахан 11 дүгээр сарын 2-ны өдөр Эрхүү дэх Монголын төлөөлөгчдийн өмнөөс Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, Д.Лосол нар гарын үсгээ зурж ЗОУ-ын ГХАК-ын төлөөлөгч болон ОК(б) Намын төв хорооны Сибирийн товчооны дорно дахины ард түмний секцэд илгээсэн бичигт “нэн даруй манай Монголын газар цэрэг мордуулан харгис Семеновын цэргийг арилган хятадын гараас гаргахыг машид яаран гуйна”¹⁵ гэжээ. 11 дүгээр сарын 17-ны өдөр Дорно дахины секцийн тэргүүлэгчид ба Монгол Төвдийн хэлтсийн коллегийн хамтарсан хурлаар тулгамдсан 10 гаруй асуудал хэлэлцэж Монголын үндэсний нэгдсэн фронтыг байгуулах тухай сэдэв боловсруулахыг Ринчинод даалгасан бөгөөд түүний бэлтгэсэн сэдвийг хожим 12 дугаар сарын 21-ний хурлаар баталжээ. Хамтарсан хурлаас партизаны отрядууд байгуулж тэдгээрийг зэвсэг болон бусад зүйлээр хангах асуудлаар 5 дугаар армийн хувьсгалт цэргийн зөвлөлд танилцуулах асуудлыг Монгол төвдийн хэлтэст даалгажээ¹⁶.

Монгол дахь Хятадын цэрэг ба Семеновтны талаар Монголын партизаны отрядуудын баримтлах тактикийн тухай асуудлыг тус хурал хэлэлцээд “Хятадууд хийгээд Семеновтан хоорондоо тэмцэлдэх үйл явцад монголын партизаны отрядууд төвийг сахиж байх ёстой бөгөөд тэхдээ аль болохоор хооронд нь мөргөлдүүлэхийг хичээн ашигтай нөхцөл тохиолдох бүрийд аль суларсан талынх нь эсрэг тэмцдэг байх, отрядууд Монголын үндэсний эрх ашгийг хамгаалах хөтөлбөрийг хатуу баримтлан, түрэмгийлэн эзлэгч хятадын цэргийн эсрэг тэмцэх явдлыг гол зорилтоо болгосон байх”¹⁷ хэрэгтэй гэж тогтжээ. Мөн башкир, татар, алтайн халимаг, буриад монгол, зарим талаар халхууд ч оролцсон Семенов - унгернийхний Монгол

дахь отрядуудыг задлан бутраах тухай асуудал хэлэлцэж “Зөвлөлт засгийн эрх мэдэл бүхий байгууллагууд, мөн холбогдох үндэсний байгууллагуудын нэрийн өмнөөс татарын болон бусад үндэстэнд хандан хэрэв тэд Унгерний отрядыг орхин явах аваас бүрэн өршөөл үзүүлж эх орондоо буцах боломжоор хангана гэсэн заалт бүхий уриалга гаргах, бас Унгерний отрядуудыг задлан бутраах зорилгыг хэрэгжүүлэх үүднээс татар, башкир ухуулагчдыг Омскоор дамжуулан ирүүлэх”-ээр шийдвэрлэжээ.

Монголын төлөөлөгчдөд Москвад амалсан ёсоор Монголын партизан нарт туслах отрядуудыг бий болгоход буриад - монголчуудыг дайчлах тухай тус хурал хэлэлцээд “Буриад монголчуудыг яаралтай дайчлах нь зүйтэй гэж үзэж, ойрын хугацаанд тийм дайчилгаа явуулахыг сибирийн хувьсгалт хорооноос хүсэхээр”¹⁸ тогтсон байна. (Коминтерн ба Монгол) Дашрамд тэмдэглэхэд энэ шийдвэр МАН-аас баримталж байсан монголчуудын үндэсний нэгдлийн үзэл санаанд яв цав нийцсэн бөгөөд монгол угсаатны нийтлэг эрх ашиг, сонирхлыг тусгаж байснаараа ардын хувьсгалыг бэлтгэн явуулахад таатай нөлөө үзүүлсэн юм.

Монголд партизаны отрядууд байгуулахын тулд Дорно дахины ард түмний секц буриад, алтайчууд, халимаг, тувачуудаас мянга гаруй хүмүүсийг дайчлав гэж 1921 оны 1 дүгээр сарын 15-нд ГХАК-ийн орлогч Л.М.Караханд Ф.Н.Гапон мэдэгджээ¹⁹. Монголын ард түмний нийтлэг үйл хэргийн төлөө тэмцэлд буриад, халимаг, туваа, алтайчууд оролцсоноор хувьсгалыг экспортолсон мэтээр нотлохыг оролддог нь явуургүй суртал нэвтрүүлэг байсан бөгөөд харин ч тэдгээр хүмүүс нь үндэстнийхээ өмнө хүлээсэн үүргээ ухамсарлан хувь нэмрээ оруулжээ гэж үзэх нь үнэнд нийшнэ. Мөн энэ үеэр Монголын төлөөлөгчид Зөвлөлт Оросын удирдлагын урьд амалсан 150 мянган алтан рубль ба зэр зэвсгийг хүлээн аваад байв.

Монголын хувьсгалчид Хятадын түрэмгий цэргийн эзлэлтээс улс орноо чөлөөлөх, барон Унгерний цагаантнуудыг улс орноосоо хөөн гаргах зорилгыг шийдвэрлэхийн тулд партизан цэрэг элсүүлэх, намын их хурлыг бэлтгэн хуралдуулах, Ардын түр засгийн газар байгуулахад шуурхай бэлтгэж цаг үеийн тулгамдсан шаардлагыг тусгасан идэвхтэй үйл ажиллагаа өрнүүлсэн билээ.

Унгерн Хүрээг эзэлж Монголын байдал улам ээдрээтэй болж байсан энэ үед буюу 1921 оны 2 дугаар сарын 10-нд

Эрхүү дэх Коминтерний Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газар (АДНБДНГ) ба Монгол-төвдийн хэлтсийн хамтарсан хурал болж, Унгерн Монголыг эзэлснээр Коминтерн ба Зөвлөлт Орос хувьсгалт баазаа алдах аюул бий болов. Приморийн мужид Семеновоор, Манжуур ба Умарт Хятадад япончууд генерал Жан Золинаар, Монголд барон Унгернээр толгойлуулсан хориглон хамгаалах бус, харин Алс Дорнодын Бүгд Найрамдах Улс (АДБНУ) ба ЗСБНХОУ-ын эсрэг чиглэсэн дайран довтлох шинжтэй хар хүчний буфер бэлтгэж байгаа нь бүх талаар батлагдаж буй тул Унгерн хийгээд түүний холбоотон Монголын феодалуудын эсрэг Монголын хувьсгалчдад идэвхтэй дэмжлэг үзүүлэх замаар тэр хар хүчний буферийн ядаж л эхний ээлжинд түүний Монгол дахь шижмийг эвдлэхэд Коминтерн ба Зөвлөлт Орос улсын дайчин зорилт оршино гэж тэмдэглээд Монголын хувьсгалчдад үзүүлэх тусламжийг түргэтгэх хэрэгтэй гэж үзжээ²⁰. Тус хурал Монголд бий болсон нөхцөл байдалтай холбогдуулан зохих практик арга хэмжээ авахыг хувьсгалт цэргийн зөвлөлд хүссэн байна.

Ийм нөхцөлд Монгол Төвдийн хэлтсийн хурлаас урьд зөвлөсөн ёсоор 1921 оны 3 дугаар сарын 13-нд Хиагтад Монгол Ардын түр засгийн газар байгуулагдав. МАН-ын Төв Хороо, Ардын түр засгийн газраас гаргасан тунхагт: “Эдгээр Оросын цагаанууд болбаас манай монголын-олон-газраа энд тэнд бүлэглэн сүрэглэж, заримдаа хүч хэрэглэж, заримдаа олон монголчуудыг гэнэдүүлэн мэхэлж явмуй. Эдгээрийн үнэн санал нь болбаас монголчуудыг хэрэглэж өөрийн битүүлэг нэгэн хэргийг бүтээсүгэй хэмээсэн нь магад”²¹ гэж тэмдэглээд тэдгээрийг орон хязгаараас даруй зайлуулах нь чухлыг заажээ. Гэхдээ энэхүү тунхагт “манай түр зуурын засгийн газраас гол болгож эрмэлзэх нь уул газар орон юугаан хятадын харгис засгийн эрх мэдлээс ангижруулан элдвийн олон зэвсэг бүхий сүрэглэн яваа хулгай дээрмүүдийг арилгах”²² явдал мөн хэмээн гэминг зайлуулах зорилгыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгсөн юм. Үүнийг Б.Шумяцкий эрс шүүмжилж В.И.Ленин, Г.В.Чичерин, Кабешкий, Я.Янсон нарт илгээсэн мэдээлэлдээ: “Ардын хувьсгалт намынхан цэргийн хүчний хувьд ямарч аюул учруулаагүй хятадын ангиуд руу хүчээ төвлөрүүлж цагаантантай тэмцэхээс зайлсхийх оролдлого”²³ хийж буй мэтээр дүгнэсэн байдаг. Гэвч МАН-ын бодлого бол нэг талаар, гол түрэмгийлэн эзлэгч хятадын цэргийг бүрэн зайлуулах, нөгөө талаар,

цагаантны дотор монголчууд олон байсан учир монголчуудыг улаан, цагаанаар хуваан мөргөлдүүлэх иргэний дайны аюулаас сэрэмжлэхийн тулд тэдгээр монгол цэргийг барон Унгернээс салган холдуулах бодлого баримталж, хүч боломжоо хоёр фронтод тарамдуулахгүй байх гэсэн хэрэг байжээ. Энэ нь зөв болж монголын партизан цэргүүд 1921 оны 3 дугаар сарын 18-нд Хиагтыг хятадын цэргээс чөлөөлж цагаантны эсрэг тэмцэлд хүч анхаарлаа төвлөрүүлэх боломжтой болсон юм.

Бас Зөвлөлт Оросын цэргийг ирүүлэх ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор Монголын Ардын түр засгийн газраас 3 дугаар сарын 16-ны өдөр ЗСБНХОУ-ын засгийн газарт цагаан гвардынхны эсрэг тэмцэлд цэргийн тусламж үзүүлэх хүсэлт тавьжээ. Энэ хүсэлтээ Ардын түр засгийн газар албан ёсоор нотолж мөн оны 4 дүгээр сарын 10-нд ЗСБНХОУ-ын засгийн газарт дахин хандсан билээ.

Монголд цэрэг оруулах асуудал шийдвэрлэхийн өмнө Унгерний хүчийг устгах байлдааны төлөвлөгөөний хоёр хувилбар яригдаж байсны нэг нь бүр 1920 оны 12 дугаар сард Б.З. Шумяцкийн санал болгосноор Монголын хувьсгалт отрядуудаар хуурах аргыг хэрэглэн Орос Монголын хил хавьд Унгернийг ирүүлж цохилт өгөх, нөгөө нь Нийслэл Хүрээ рүү цэрэг аялуулах төлөвлөгөө байжээ. Энэ асуудлын талаар 1921 оны 6 дугаар сарын 1-нд ОК(б) намын Алс дорнодын товчоо ба ЗСБНХОУ-ын ГХАК-ын төлөөлөгчдийн хамтарсан хурлаар хэлэлцэж нэлээд маргалдсаны эцэст хоёр дахь хувилбар зөвшөөрөгджээ. Олонхийн саналаар зөвшөөрсөн тогтоолд:

1. Монголд ажиллагаа явуулах нь АДБНУ ба Зөвлөлт Орос улсын хүчин чадлыг харуулах, манай ар талыг хангах, Жан Золинг эсэргүүцэх, Хятад ба Монголын хувьсгалт хүчийг бэлтгэх аргын хувьд чухал.

2. Зорилт нь Унгернийг бүрмөсөн устгах, Нийслэл Хүрээ, Хилийн районыг “цэвэрлэх”, тэнд Монголын үндэсний засгийг тогтоох явдал.

3. Засаг нь зөвлөлтийн биш, үндэсний байх ёстой бөгөөд монголын бие даахыг биш, харин хятадын холбооны үндсэн дээр автономи тогтоохыг зоривол зохино гэж заажээ²⁴.

1921 оны 6 дугаар 16-нд ОК(б) намын ТХ-ны улс төрийн товчооны хурлаас Улаан арми ба АДБНУ-ын цэргийн ангиудыг Монголд оруулах тухай удирдамжийг баталжээ. Уг удирдамжид

“монгол дахь хятадын бүрэн эрх болон монголын үндэсний эрх чөлөөгөө олж өөртөө тохинох хөтөлбөрийг яв цав баримтлах”, Ардын хувьсгалт намтай харилцаа холбоотойгоор монголын улаан цэргийн ангиудтай хамтран ажиллах мөн монголын олон түмний ахуй байдал, зан суртахуун, ялангуяа буддын сүм хийдэд болгоомжтой хандахыг” анхааруулжээ. (РГАСПИ ф.17, Оп.3.Д.176.Л.1) 6 дугаар сарын 22-ны өдөр В.Г. Чичерин ОК(б)Н-ын төв хорооны Алс Дорнодын товчоонд Монголын нутаг дэвсгэр дээр Унгерний эсрэг цэргийн ажиллагааг эхлэх заалт өгчээ.

5-р арми, АДБНУ-ын ардын хувьсгалт арми, МАХА-ийн хамтын ажиллагаа эхэлснээр цагаантны эзлэлтээс Монгол орныг чөлөөлөх таатай нөхцөл бүрэлдсэн юм. Хиагтын орчимд Сүхбаатарын морьт цэрэг Унгерний түрэлт ба Баяр гүний отрядад цохилт өгч ухраасан нь цэргийн бусад ангиудын ажиллагаанд шийдвэрлэх ач холбогдолтой болсон ажээ. 6 дугаар сарын дундуур Монгол, Оросын хил орчмын нутгуудад Унгерн, Резухин нарын цэрэг удаа дараа цохилт хүлээж монголын нутгийн гүн руу ухрахаас аргагүйд хүрчээ. Нейманы удирдсан аялан байлдах корпус ба монголын ардын журамт цэргүүд 6-р сарын 28-нд Нийслэл Хүрээний зүг өргөн давших ажиллагаа явуулсан юм. Харин тэд бараг эсэргүүцэлтэй тулгаралгүй явсаар тэргүүний ангиуд нь 7 дугаар сарын 6-нд Нийслэл Хүрээнд орсон билээ. 10-ний өдөр засгийн бүх эрх Ардын засгийн мэдэлд шилжив. Монголын үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцэлд МАН эх оронч бүх хүчнийг оролцуулах нэгдсэн фронтын тактик баримталж байсны дагуу засгийн газрын бүрэлдэхүүнд МАН-ын гишүүдээс гална лам, ноёдын төлөөлөгчдийг ч оролцуулж Богд гэгээнийг хэмжээт эзэн хаанаар өргөмжилөв. Монголын Ардын засгийн газар Унгерний хүчийг бут цохин халхыг чөлөөлөвд Баруун Монголын нутагт эзэгнэж байсан цагаантны хүчийг устгах ажилд яаравчлан оржээ. 1921 оны 7-р сарын сүүлчээр Монголын цэрэг Улиастайд үүрлэж байсан Казанцевийн дээрэмчдийг устгаад 12 дугаар сарын эхээр Улаангом, Ховдын районд байлдааны ажиллагааг амжилттай явуулсны үр дүнд генерал Бакич, Карнаухов нарын отрядуудыг бут цохин устгаснаар Гадаад Монголын бүх нутаг цагаантнаас чөлөөлөгдсөн юм.

1921 оны 8 дугаар сард Унгернийг монгол цэргүүд баривчилж Зөвлөлт Оросын улаан цэргийн ангид шилжүүлснээр барон Унгерний Монгол дахь ажиллагаа төгсгөл болж түүний

хувь заяа Зөвлөлт Орост шийдвэрлэгдсэн болой.

Унгернийг шүүхэд шилжүүлэх тухай саналыг ОК(б)Н-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1921 оны 8 дугаар сарын 29-ний хуралдааны 55-р протоколын 2 дахь зүйлд баталжээ. Тус хуралд оруулсан саналын талаар В.И.Лениний цохолт байх бөгөөд түүнд: “Энэ хэрэгт маш анхааралтай хандаж ялын үнэн магадтайг шалгаж бүрэн дүүрэн нотлогдсон тохиолдолд л ил шүүх ажиллагааг яаравчлан зохион байгуулж, буудвал зохино гэдэгт эргэлзээ байж болохгүй юм байна” гээд гарын үсгээ зуржээ. Үүний дагуу Новоникалавск дахь хувьсгалт цэргийн шүүх Унгерний хэргийг шүүж, түүний бурууг нотлон хуулийн дээд хэмжээний ял ногдуулж, ёсоор гүйцэтгэсэн ажээ.

ИШ ТАТСАН СУРВАЛЖ, БҮТЭЭЛ

13. Коминтерн ба Монгол (баримтын эмхтгэл)УБ. 1996. 24 дэх тал.
14. РГАСПИ (Российский государственный архив современной политической истории). Ф.495, Оп. 152, Д.3, Л.12-13.
15. Монгол Ардын хувьсгалт намын тогтоол, шийдвэр, баримт бичгүүд. Нэгдүгээр боть. 1920-1928 он. УБ.1981 он, 14 дэх тал.
16. РГАСПИ.Ф.495, оп.154.Д.9.Л.1.
17. Мөн тэнд.
18. Мөн тэнд.
19. Мөн тэнд.Д.105.Л.1.
20. Мөн тэнд.Д.89.Л.2.
21. Монгол Ардын хувьсгалт намын тогтоол шийдвэр, баримт бичгүүд. Нэгдүгээр боть. 53 дахь тал.
22. Мөн тэнд.
23. РГАСПИ. Ф.495, Оп.152.Д.59.Л.22.
24. Мөн тэнд. Ф 372.Оп.1.Д.61, Л.59.
25. Мөн тэнд Ф.17.Оп.3, Д.176.Л.1.
26. Мөн тэнд. Ф.17.Оп. 163, ед.хр. 178.Л.5.